

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАРИМ ИРГЭДИЙН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1990 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр баталсан БНМАУ-ын Тэтгэврийн хуульд заасан дараах болзол, нөхцөлөөр өндөр насын тэтгэвэр тогтоолгосон доор дурдсан иргэдийн сард олгох тэтгэврийн хэмжээг 50 000 төгрөгөөр нэмэгдүүлж, тэтгэврийн нэмэгдэлд зарцуулах хөрөнгийг жил бүр улсын төсвөөс олгоно:

1.1. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөж хүмүүжүүлсэн 15-аас доошгүй жил ажилласан, 50 насанд хүрсэн нөхцөлөөр өндөр насын тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй;

1.2. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөж хүмүүжүүлсэн, 20-иос доошгүй жил ажилласан, нас харгалзахгүй нөхцөлөөр өндөр насын тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй;

1.3. Нийтдээ 27-оос дээш жил ажилласан, нас харгалзахгүй нөхцөлөөр өндөр насын тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй;

1.4. Нийтдээ 32-оос дээш жил ажилласан, 55 насанд хүрсэн нөхцөлөөр өндөр насын тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу тогтоосон хэмжээгээр тэтгэвэр авагчдын тэтгэврийг тооцож олгох журмыг Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг